

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУДЫН ХАРИУЛТ

Аль ангиуд, ямар хичээлээр стандартад суурилсан тайланг ашиглах вэ?

Цэцэрлэгээс тав хүртэлх ангийн сурагчдад Англи хэл, Зураг, Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Дуу хөгжим, Биеийн тамирын хичээлүүдээр стандартад суурилсан ахицын тайланг ашиглах болно.

Стандартад суурилсан ахицын тайланг хүүхдэд хэдэн удаа хийж өгөх вэ? Цэцэрлэгийн хүүхдүүдэд энэхүү ахицын тайланг жилд хоёр удаа харин нэгээс тавдугаар ангийн сурагчдад улирал тутамд гаргаж өгөх болно.

Сурагчдын сурлагын түвшинг багш хэрхэн тодорхойлох вэ? Улирлын туршид багш төрөл төрөл бүрийн арга, тухайлбал бичгийн шалгалт, төсөлт ажил, тест, таавар, бүтээлч даалгавар болон ажиглалт зэргийг ашиглан сурагчдын ахицыг тодорхойлох баримт цуглуулах бөгөөд эдгээрт үндэслэн үнэлгээг хийнэ.

Энэ нь сурагчдад ямар ашигтай вэ?

Сурагчид олж авах ёстой ур чадвар, үндсэн ойлголтуудынхаа талаар тодорхой ойлголттой болно. Эцэг эхчүүд хүүхдийнхээ сайн эзэмшсэн агуулга, эсвэл хоцорсон талуудыг олж мэдсэний үндсэн дээр анхаарч ажиллах боломжтой болно.

Стандартад суурилсан ахицын тайланг бид бага ангийн түвшинд хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ талаар эцэг эх болон бусад талуудын саналыг сонсох болно.

Стандартад суурилсан сургалт түүнийг хэрхэн дүгнэж, ахицын тайланг гаргах талаарх мэдээллийг доорх сайтаас авна уу:

www.apsva.us/standards-based-instruction

Стандартад суурилсан сургалт, түүнийг хэрхэн дүгнэж, ахицын тайлан гаргах талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэт **Сургалтын Албаны Захирал Сара Путнэмтэй** sarah.putnam@apsva.us цахим шуудангаар харилцана уу.

Syphax Education Center
2110 Washington Blvd.
Arlington, VA 22204

БАГА СУРГУУЛИЙН СТАНДАРТАД СУУРИЛСАН АХИЦЫН ТАЙЛАН



Arlington
Public
Schools

ЭЦЭГ ЭХЭД ЗОРИУЛСАН ЛАВЛАХ

Стандартад суурилсан тайлангаар эцэг эх/асран хамгаалагчид хүүхдийнхээ Виржиниагийн Суралцахуйн Стандарт болон анги тус бүрээр тогтоосон АТӨС-ийн Суралцахуйн агуулгын эзэмшилтэд суурилсан суралцах үйл явцын ахицын талаарх мэдээллийг олж авах болно. Энэхүү ахицын тайлан хүүхдийн амжилт болон цаашид илүү сайжрах боломжийг илрүүлэн гаргах юм.

ОРШИЛ

АТӨС нь 17 бага сургуульдаа стандартад суурилсан ахицын тайланг нэвтрүүлж байна. Ахицын тайлангийн энэхүү шинэ хэлбэр нь сурагчдын олж авч буй шинэ ур чадвар, мэдлэгийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг агуулах болно.

Стандартад суурилсан тайлангаар тэдний олж авч буй мэдлэгийг уламжлалт үсгэн аргаар дүгнэхгүй. Стандартад суурилсан үнэлгээний арга нь:

- Багшлах, суралцахуйн үйл явцтай илүү тохирно.
- Сурагчид юу сурч, хийж чаддаг болсонд анхаарна.
- Ахицын талаар илүү тодорхой мэдээлэл агуулна.
- Сурагчдыг оролцуулна.

АТӨС-ийн сургалтын үйл явцад ашигладаг сургалт семинарын загварчлал, тусгай эргэх холбоо болон зорилтот сургалтын арга зэрэг нь энэхүү зорилгыг дэмжиж байгаа юм.

Сурагчид зорилгоо өөрсдөө тодорхойлж, стандартыг бүрэн эзэмшихийг хичээж, гаргаж буй ахицынхаа талаар эргэцүүлэх болно.

СТАНДАРТАД СУУРИЛСАН АХИЦЫН ТАЙЛАНД ЯАГААД ШИЛЖИХ БОЛОВ?

- **Илүү утга учиртай:** Стандартад хүрэх хүүхдийн ахицын талаар тодорхой мэдээллийг агуулна.
- **Үнэн зөв байдал:** Сурагчдын мэдэж буй зүйлийн талаарх тодорхой эргэх холбоо үүсгэх,
- **Тууштай байдал:** Сурагчдыг дүгнэх явц дахь хувь хүний нөлөөг арилгаж, сурагчид өөрөөс нь юу хүлээж буйг тодорхой мэдэх
- **Суралцах үйл явцыг дэмжинэ:** Багш хүүхдийн суралцах үйл явцын талаар мэдээлж, сургалтын үйл явцыг сурагчдын хэрэгцээнд тулгуурлан өөрчлөх боломжтой

АХИЦЫН ШИНЭ ТАЙЛАН ЯМАР БАЙХ ВЭ?

Хичээл бүрээр Виржиниагийн стандарт болон стандартын дагуу эзэмшсэн талаарх зэрэглэлийг тусгана. Нийгэмших болон бусад ажлын ур чадваруудыг бас тусгах болно. Үсгээр илэрхийлдэг үнэлгээний оронд стандарт үзүүлэлттэй харьцуулах таны хүүхдийн ахицыг харуулах болно. Түвшин бүрийг доор тайлбарласан болно.

АТӨС-ийн СТАНДАРТАД СУУРИЛСАН СУРЛАГЫН ТҮВШИНГИЙН АХИЦЫН ТАЙЛАН

- **Стандартыг бүрэн хангаж байна:** Сурагч стандарт түвшнийг бүрэн эзэмшсэнээ харуулсан.
- **Стандартыг бүрэн хангахад ойртсон:** Сурагч стандартыг хангахад ойртсон.
- **Стандарт хангах үйл явцад явж байгаа:** Сурагч стандартын үндсэн ойлголтыг бусдыг тусламжтайгаар авч чадна.
- **Хангалттай нотолгоо үгүй:** Тухайн ур чадварыг сурагч эзэмшсэн талаарх нотолгоо багшид байхгүй байна.

